



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА

2025.02.14

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2024 оны жилийн эцсийн байдлаар үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийлээ.

Үйл ажиллагааны хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон түүний харьяа байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам” -ыг тус тус үндэслэл болгов.

Хоёр. Танилцуулга:

2.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 5 зорилтын 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, бүрэн хэрэгжсэн 14 арга хэмжээ, 90 хувийн 14, 70 хувийн 1, 30 хувийн 5, тасарсан 1 арга хэмжээний хэрэгжилт **82.3** хувь байна. Хэрэгжилтийн үнэлгээг хүснэгтээр үзүүлбэл:

/Хүснэгт1/

№	Зорилт	Нийт	Үүнээс /хувиар/						ХБ	Үнэлгээ /хувиар/
			100	90	70	50	30	0		
1	1	7	6	1	-	-	-	-	-	98.5
2	2	6	1	5	-	-	-	-	-	91.6
3	3	8	2	4	-	-	2	-	-	77.5
4	4	11	4	2	1	-	3	1	-	67.3
5	5	3	1	2	-	-	-	-	-	93.3
Нийт		35	14	14	1	-	5	1	-	82.3

2.2. Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт:

Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрээр 2024 оны жилийн эцсийн байдлаар тус газарт өгөгдсөн 7 үүрэг даалгаврын дундаж үнэлгээ 90.0 хувь байна. Доорх хүснэгтээр дэлгэрэнгүй байдлаар үнэлгээг үзүүлбэл:



/Хүснэгт 2/

№	Шийдвэрийн төрөл	Нийт	Хэрэгжилтийн үнэлгээ /хувиар/						Үнэлгээ /хувиар/
			100	70	30	0	Хугацаа болоогүй	Хяналтаас хассан	
1	УИХ-ын тогтоол	1	-	-	-	-	1	-	-
2	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	6	4	2	-	-	-	-	90.0
Нийт		7	4	2	-	-	1	-	90.0

2.3. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт:

2024 оны жилийн эцсийн байдлаар тус газарт сайдын тушаалаар 72 үүрэг даалгавар өгөгдсөн байна. Эдгээрээс бүрэн хэрэгжсэн 22, 70 хувийн 35, 30 хувийн 13, хугацаа болоогүй 2 арга хэмжээний дундаж үнэлгээ **72.0** хувь байна. Үнэлгээний задаргааг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 3/

Нийт	Хэрэгжилтийн үнэлгээ /хувиар/						Үнэлгээ /хувиар/
	100	70	30	0	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
72	22	35	13	-	2	-	72.0

2.4. Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн 33 үүрэг даалгаврын хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн 16, 70 хувийн 13, 30 хувийн 3, хугацаа болоогүй 1 арга хэмжээний дундаж үнэлгээ **81.2** хувьтай байна.

/Хүснэгт 4/

Нийт	Хэрэгжилтийн үнэлгээ /хувиар/						Үнэлгээ /хувиар/
	100	70	30	0	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
33	16	13	3	-	1	-	81.2

2.5. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хуулийн хэрэгжилт:

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан тус газар ил тод байдлын 2 шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаж байна. Эдгээр арга хэмжээний дундаж үнэлгээ 100.0 хувьтай байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтэд тус газраас улирал бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллаж байна.



3. Үнэлгээ, үнэлэлт, дүгнэлт:

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон түүний харьяа байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”-ыг тус тус баримтлан Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын үйл ажиллагаанд 2024 оны жилийн эцсийн байдлаар үнэлгээ хийлээ. Газрын үйл ажиллагааг дүгнэхдээ 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт зэрэг 5 чиглэлийн үйл ажиллагааны дундаж үнэлгээ **77.6** хувь байна.

Доорх хүснэгтээр үнэлгээг нэгтгэж үзүүлэв.

/Хүснэгт 5/

№	Арга хэмжээний нэр	Нийт	Үнэлгээ /хувиар/							Хүчингүй болсон	Хэрэгжилт /хувиар/
			100	90	70	50	30	0	ХБ		
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөө	35	14	14	1	-	5	1	-	-	82.29
2	Хууль тогтоомж	7	4	-	2	-	-	-	1	-	90.0
3	Сайдын тушаал	72	22	-	35	-	13	-	2	-	72.0
4	ТНБД-ын тушаал	33	16	-	13	-	3	-	1	-	81.25
5	Ил тод байдал	2	2	-	-	-	-	-	-	-	100.0
Нийт		149	58	14	51	-	21	1	4	-	77.6

3.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2024 оны үйл ажиллагааны хэрэгжилтийг дүгнэхэд 5 чиглэлийн 149 арга хэмжээний дундаж үнэлгээ **77.6** хувь байна.

3.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын үйл ажиллагааны онцлог нь тогтмол байнгын давтагдах шинжтэй байдаг. 2024 онд тус газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан дотоод аудит болон санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр хийгдэхээр төлөвлөсөн 5 арга хэмжээ болон хяналт-шинжилгээ, үнэлгээний журам шинэчлэн батлуулж, хяналт-шинжилгээний үнэлгээний программыг яам, салбарын харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилт хангалтгүй байсан байна.

3.3. Тус газарт сайдын тушаалаар 2024 оны жилийн эцсийн байдлаар 72 үүрэг даалгавар өгөгдсөн байна. Эдгээрээс бүрэн хэрэгжсэн 22, 70 хувийн 35, 30 хувийн 13, хугацаа болоогүй 2 арга хэмжээний дундаж үнэлгээ **72.0** хувьтай. Сайдын тушаалаар



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт хагас жилийн үнэлгээтэй харьцуулахад 5.7 функцээр үнэлгээ буурсан ба 30 хувийн хэрэгжилттэй 5 арга хэмжээ нэмэгдсэн байна.

4. Санал, зөвлөмж:

4.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2025 гүйцэтгэлийн төлөвлөгөөнд салбарын хэмжээнд санхүүгийн болон дотоод аудитын төлөвлөгөөт хяналт шалгалт хийх ажлыг эрчимжүүлэх, төлөвлөсөн арга хэмжээг хугацаанд хийх, удирдлагад танилцуулж, зөвлөмж чиглэл авч, шалгалтын үр дүнг тооцож ажиллах,

4.2. Салбарын хэмжээнд хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулан, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг бууруулан стандарт, норм, нормативын хэрэгжилтэд хяналт тавих арга хэмжээг эрчимжүүлэх;

4.3. Сайд, төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн тушаалын хэрэгжилтэд хамтран биелүүлэх үүрэг даалгаварт байнгын хяналт тавих, хэрэгжилт удаашралтай болон эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг хяналтад авч, хариуцсан мэргэжилтэнд хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллах;

4.4. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг анхаарч, нийтэд ил тод мэдээ мэдээллээр хангаж, тус газрын хариуцсан мэдээллийг тухай бүр шинэчлэх, бүрэн байршуулах, мэдээллийн эх сурвалжийг мэдээлж ажиллах;

4.5. Яамны болон харьяа байгууллагын хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээний программын хэвийн ажиллагааг хангуулж, бодлогын баримт бичиг болон төлөвлөгөөний биелэлтийг программаар авч, үнэлж, эхлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журамд өөрчлөлт орсон даруйд одоо мөрдөж буй журмыг шинэчлэн батлуулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэхийг тус тус зөвлөж байна.

ХШҮДАГ



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

№	Арга хэмжээний нэр	Нийт	Үнэлгээ /хувиар/							Хүчингүй болсон	Хэрэгжилт /хувиар/
			100	90	70	50	30	0	ХБ		
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөө	35	14	14	1	-	5	1	-	-	82.29
2	Хууль тогтоомж	7	4	-	2	-	-	-	1	-	90.0
3	Сайдын тушаал	72	22	-	35	-	13	-	2	-	72.0
4	ТНБД-ын тушаал	33	16	-	13	-	3	-	1	-	81.25
5	Ил тод байдал	2	2	-	-	-	-	-	-	-	100.0
Нийт		149	58	14	51	-	21	1	4	-	77.6

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2024 оны үйл ажиллагаанд хийсэн нэгдсэн дүнг графикаар үзүүлвэл:

